# Шинжээчийнтайлан

Байгууллагын нэр: Дархан дээд сургууль

Хөтөлбөрийн нэр: “ Багш,бага ангийн боловсрол” бакалаврын мэргэжлийн хөтөлбөр

Индекс: D011301

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Энхцэцэг

Гишүүд: Л.Алтансувд

Д.Алтайхүү

Р.Өлзийхишиг

Он сар өдөр: 2022.04.04

**Агуулга**

**Товчилсон үгийн тайлбар**
**I.Хөндлөнгийн үнэлгээ хийхүйлявц,төлөвлөлт**
**II.Сургалтын хөтөлбөрийнтанилцуулга**
**III.Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**
Шалгуур1:Хөтөлбөрийн төлөвлөлт
Шалгуур2: Сургалтын үйл ажиллагаа
Шалгуур3:Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл
Шалгуур4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт
Шалгуур5:Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа
Шалгуур6:Багшийн үйл ажиллагаа
Шалгуур7:Чанарын үнэлгээ, баталгаажилт
**IV.Уулзалтад оролцогчдын нэрс**
I. Багш нарыннэрс
II. Оюутнуудын нэрс
III. Ажилолгогчдын нэрс.
IV. Төгсөгчдийн нэрс
**V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**
**YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**
**YII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл (БМИҮЗ)
ДаДэС- Дархан Дээд Сургууль
ШУА- Шинжлэх Ухааны Академи
БСШУЯ- Боловсрол, Соёл,Шинжлэх Ухааны Яам
ДБМИҮЗ –Дээд Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
STEEP шинжилгээ – Нөхцөл байдлын шинжилгээ
ОХУ- Оросын Холбооны Улс
БНХАУ- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨМӨЗО- Өвөр Монголын Өөртөө Засах Орон
СӨНХ- Сургуулийн өмнөх насны хүүхэд
МХТ- Мэдээлэл, харилцааны технологи
UNESCO- НҮБ-ын боловсрол, соёл,шинжлэх ухааны байгууллага
STEAM – Сургалтын нэгдмэл аргазүй
Course Learning Outcomes (CLO) –Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар:
Program Learning outcomes (PLO)- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, урчадвар:
ULMS-Удирдлагын Мэдээллийн систем
ДаДэС-ийн ҮАМДЖ-Дархан Дээд Сургуулийн Үйлажиллагаанд мөрдөх дүрэм, журам
НХХэлтэс- Нийгмийн Халамжийн Хэлтэс
ДархансумынЗДТГазар- Дархан сумын Засаг даргын тамгын газар
SPSS- Математик, Статистик Тооцоолол
Lib4U- номын сангийн цахим программ
ЭЕШ- Элсэлтийн Ерөнхий Шалгалт
Educational Program-Сургалтын хөтөлбөр
Curriculum-Сургалтын төлөвлөгөө
Program educational objectives (PEO)- Хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтууд
Program Learning outcomes (PLO)-Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, урчадвар
Knowledge-Мэдлэг
Education-Боловсрол
Content-Агуулга
Capacity-Чадавхи
Ability-Чадвар
Skill-Дадал
Competency-Чадамж
Syllabus-Хичээлийн хөтөлбөр
Assessment-үнэлгээний судалгаа
Evaluation-Үнэлгээ

# I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц,төлөвлөлт

<table>
<tr><td>Сургуулийннэр /Монгол, Англи/</td><td colspan="2">Дархан дээд сургууль</td></tr>
<tr><td>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</td><td colspan="2">“Багш, бага ангийн боловсрол”</td></tr>
<tr><td>Индекс</td><td colspan="2">D011301</td></tr>
<tr><td>Шинжээчид</td><td colspan="2">Ахлагч: Д.Энхцэцэг:МУБИС-ийн, Багшийн сургуулийн доктор,профессор<br>Гишүүд: Л.Алтансувд:МУБИС-ийн СӨБС-ийн сургуулийн хөтөлбөрийн албаны дарга, доктор<br>Д.Алтайхүү: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУС-ийн дэд профессор, доктор<br>Р.Өлзийхишиг: Нийслэлийн ерөнхий боловсролын 34</td></tr>
<tr><td>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</td><td colspan="2">Б. Соёлмаа - БМИҮЗ-ийн дотоод аудит, байгууллагын чанарын баталгаажуулалт хариуцсан шинжээч</td></tr>
<tr><td rowspan="8">Төлөвлөгөө</td><td>Он сар өдөр</td><td>Хийгдсэнбайхажлууд<br>/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/</td></tr>
<tr><td>2022.02.23</td><td>Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.</td></tr>
<tr><td>2022.02.24-25</td><td>Сургуульд тодруулах асуулт, дахин сайжруулж бэлтгэл ажлыг хангуулах</td></tr>
<tr><td>2022.02.28<br>2022.03.01</td><td>Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.</td></tr>
<tr><td>2022.03.14</td><td>Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.</td></tr>
<tr><td>2022.03.15</td><td>Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.</td></tr>
<tr><td>2022.03.17</td><td>Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.</td></tr>
<tr><td>2022.03.18</td><td>Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.</td></tr>
<tr><td>Шалгуур шаардлага /журам/</td><td colspan="2">БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”,“Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага”, БСШУС-ын сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, Бусад холбогдох дүрэм, журмууд</td></tr>
</table>

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Багш, бага ангийн боловсрол хөтөлбөр нь БСШУ-ны сайдын 2014 оны 03 сарын 13-ны өдрийн А/78 тоот "Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу "Боловсрол судлал" мэргэжлийн ерөнхий чиглэлд багтдаг бие даасан хөтөлбөр юм. Тус хөтөлбөрөөр суралцан төгсөгч нь монгол улсын боловсролын салбарын хөгжилд мэргэжлийн чиглэлээр зохих хувь нэмрийг оруулдаг, багаар хамтран ажилладаг, мэдлэг, боловсрол, чадвараа тасралтгүй дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй, бүтээлчээр сэтгэж ажилладаг, боловсролын удирдахуйн ухааны үндсэн ойлголттой ерөнхий боловсролын сургуульд бага ангийн багшаар ажиллах чадвартай, боловсрол судлалын чиглэлээр зохион байгуулагч, судлаач мэргэжилтэн болно.

Бага ангийн багш мэргэжлээр бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь төрийн болон хувийн хэвшлийн сургалтын байгуулагад боловсрол судлалын чиглэлээр мэргэжлийн болон сургалт, судалгааны ажил эрхлэх онол арга зүйн, практик аргачлалын мэдлэг, чадвар олгоно.

Сүүлийн жилүүдэд боловсролын салбар эрчимтэй хөгжиж байна. Энэхүү хөгжлийг дагаад багш мэргэжилтэн, тэр дундаа бага ангийн багшийн хэрэгцээ улам бүр өсөх хандлагатай болсон тул Дархан дээд сургууль нь багш, бага ангийн багш хөтөлбөрөөр 2012 оноос өдрийн сургалт явуулж эхэлсэн түүхтэй.

Тус хөтөлбөрөөр 2016-2021 оныг хүртэл нийт 6 удаагийн төгсөлтөөр 206 мэргэжилтэн бэлтгэн гаргаж төрийн болон хувийн ерөнхий боловсролын сургуулиудад, бага ангийн багш, арга зүйч зэрэг албан тушаалуудад ажиллаж, төвийн бүсийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж байна.

Хөтөлбөрөөр төгсөгчдийн онцлох ажлуудыг дурдвал:

- 2015-2020 онуудад МУБИС-иас багш бэлтгэдэг их дээд сургуулиудын дунд зохион байгуулдаг "Багшлахуйн ур чадвар" олимпиадад 5-н удаа оролцсноос 2 удаа гутгаар байр, 2 удаа шилдэг хэрэглэгдэхүүн номинацитайгаар амжилттай оролцсон.
- Үндэсний лобатори Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн бага ангийн багш Б. Саранчимэг Дархан-Уул аймгийн хэмжээнд зохион байгууллагдсан сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаанд 2021, 2022 онуудад ганцаарчилсан болон багийн төрөлд 2 удаа тэргүүн байр эзэлж үндэсний илтгэлийн уралдаан оролцохоор шалгарсан.
- Нийт төгсөгчдийн 85% нь мэргэжлээрээ ажиллаж байгаа нь төгсөгчдийн давуу тал болно.

# III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

## Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

**1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:**

- Ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд STEEPдүн шинжилгээ хийсэн
- Гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа хийсэн
- Улсын хэмжээний ЕБС-д элсэгчдийн судалгаа болон Бага боловсролын 1 багшид ноогдох хүүхдийн тоо, Дархан-Уул аймагт ажиллаж буй БАБ-ийн аль сургуульд төгссөн байдлын судалгаа, тухайн аймгийн хүн амын өсөлтийн судалгаа, Дархан-уул аймгийн 29 сургуульд суралцаж буй суралцагчдын судалгаа хийсэн

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- БАБ-ын салбарын цаашдын хөгжлийн ирээдүйн төлөвийг тодорхойлохын тулд ирээдүйн чиг хандлага, тулгарах бэрхшээл болон боломжийг нэгтгэн харах нөхцөл байдлын STEEP шинжилгээ хийсэн
- Дархан-Уул аймагт 2017-2021 онд үйл ажиллагаа явуулж буй 29 сургуулийн 1-5-р ангид суралцагчдын тоон судалгааг хичээлийн жил жилээр гаргасан.
- Дархан-уул аймгийн хүн амын өсөлт дээр тулгуурлан бага ангийн багшийн эрэлт хэрэгцээг тодорхойлсон.БАБ-ын салбарын цаашдын хөгжлийн ирээдүйн төлөвийг тодорхойлохын тулд ирээдүйн чиг хандлага, тулгарах бэрхшээл болон боломжийг нэгтгэн харах нөхцөл байдлын STEEP шинжилгээ хийсэн.

**Анхаарахасуудал:**

- Өөрийн хөтөлбөрийг ОХУ-аас Улан-Удэ багшийн коллеж, МУБИС, ХИС, Гурван-эрдэнэ сургуулиудын БАБ хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилгыг жагсаан бичсэн боловч харьцуулсан дүгнэлт хийгээгүй.

- ОХУ-аас Улан-Удэ багшийн коллеж, МУБИС, ХИС, Гурван-эрдэнэ сургуулийн БАБ бэлтгэх хөтөлбөрийн агуулгын багтаамж болон тухайн хөтөлбөрийн ижил ба ялгаатай талуудыг харьцуулан гаргаж чадсангүй. Харьцуулсан дүгнэлт хийгдээгүй учраас хөтөлбөрөө хэрхэн сайжруулах нь тодорхойгүй.
- Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалсан эсэх, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэгдсэн эсэх нь тодорхойгүй
- “Багш, бага боловсрол”-ын хөтөлбөрийн зорилго, зорилт болох (PEO), хөтөлбөрийн сургалтын үр дүнгүүд болох (PLO) -ийн холбоо хамаарлыг хэрхэн тусгаж, хөтөлбөрийг боловсруулах, дэлхийн чиг хандлагатай хэрхэн нийцэж буйд дүн шинжилгээ хийгээгүй.
- Суралцахуйн үр дүнгийн хэсэгт хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талууд буюу ажил олгогчид, мэргэжлийн байгууллагууд, багшлах бүрэлдэхүүн, төгсөгчид, оюутнуудаас санал асуулга авч, оюутны эзэмших хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй.

**Зөвлөмж:**

- “Багш, бага боловсрол”-ын хөтөлбөрийн зорилго, зорилт болох (PEO), хөтөлбөрийн сургалтын үр дүнгүүд болох (PLO) -ийн холбоо хамаарлыг хэрхэн тусгаж, хөтөлбөрийг боловсруулах, дэлхийн чиг хандлагатай хэрхэн нийцэж буйд дүн шинжилгээ хийх

**1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар болон SWOT шинжилгээ ӨҮТ30-31
- Хөтөлбөрийн тодорхойлолт, үндэслэл, зорилго, зорилт, хөтөлбөрийн хүрэх үр дүн болон сургуулийн алсын хараа, эрхэм зорилготой хэрхэн нийцэлтэй байгааг тодорхойлсон баримт бичиг ӨҮТ32-35
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэх процесс болон оролцогч талуудын өгсөн саналуудыг хөтөлбөрийн шинэчлэлд хэрхэн тусгасан баримт материал ӨҮТ36-39

**Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг нийтлэг байдлаар тодорхойлсон.

- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохдоо оролцогч талуудын саналыг тусгасан
- Хөтөлбөрийн үндэслэл, зорилго зорилтыг боловсруулсан
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг сургуулийн эрхэм зорилготой уялдуулсан

**Анхаарах асуудал:**

- Төгсөгчийн загвар нь БАБ мэргэжлийн чадамж нь хэт ерөнхий байна. Мөн ямар үзэл баримтлал дээр тулгуурлан боловсруулсан нь тодорхойгүй.
- Хөтөлбөрийн зорилго ба үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагын нийцэлд тодорхой дүгнэлт хийгээгүй
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийг олон нийтэд хэрхэн мэдээлсэн баримт материал тусгагдаагүй

**Зөвлөмж:**

- “Багш, бага боловсрол” Хөтөлбөрийн зорилго, зорилтоо тодорхойлохдоо ажил олгогч байгууллагууд болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусгахад анхаарах

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөр болон нэгдсэн төлөвлөгөөний шинэчлэгдсэн байдал ӨҮТ40-41
- Батлагдсан төлөвлөгөө ӨҮТ41-44
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүд болох (CLO) хамаарлын матриц ӨҮТ55-56

**Шалгуурыг хангасан байдал:Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2014 оны А/174 тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг баримтлан сургалтын хөтөлбөрүүдээ шинэчлэн сайжруулсан

**Анхаарахасуудал:**

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүд болох (CLO) хамаарлын матрицыг гүйцэд хийгээгүй байна

- Хичээлийн хөтөлбөрийг баталгаажуулахдаа сургалтын арга зүйн болон, үнэлгээний олон талт арга хэлбэрийг хэрхэн тусгасан нь тодорхой харагдахгүй байна
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн лекц, семинар, бие даалтын цагийн харьцааг судлах

**Зөвлөмж:**

- “Ерөнхий суурь”, “Мэргэжлийн суурь”, “Мэргэшүүлэх” хичээлүүдийн сонгоны хичээлүүдийн тоог нэмэгдүүлж жинхэнэ утгаар сонголт хийлгэх боломжийг бүрдүүлэх
- Багшлах дадлагуудыг сонгон бус заавал судлах хичээлийн багцад оруулах
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүд болох (CLO) хамаарлын матрицыг “Мэргэжлийн суурь”, “Мэргэшүүлэх” хичээлүүдийг бүгдийг хамруулан нэгдсэн байдлаар хийх

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл
Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц ӨҮТ52
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд ӨҮТ55-56
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ ӨҮТ55-59
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ ӨҮТ59-61
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/ ӨҮТ55-56
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа ӨҮТ62-63

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага**

- Сургалтын агуулга хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн.
- Сургалтын агуулга дадлагын харьцаа боломжтой
- Оюутан улиралд 13-15 кр сонгон хичээллэдэг нь ачаалал хэвийн

**Анхаарах асуудал:**

- Хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц гүйцэд бус зөвхөн 1 хичээл дээр жишиг байдлаар гаргасан нь хөтөлбөрийг гүйцэд системтэйгээр харах боломжгүй
- Сургалтын төлөвлөгөөнд сонгох хичээлийн кредитийг харахад бүгдийг заавал судлахаар тусгагдсан байна
- Мэргэжлийн хичээлийн сонгоны хэсэгт дадлагуудыг байршуулсан нь дадлага хийж ч болно, хийхгүй байж ч болох алдаатай төлөвлөлт харагдаж байна
- Зарим хичээлийн залгамж холбоо сургалтын төлөвлөгөөнд бичигдээгүй байна
- Сургалтын удирдлага мэдээллийн системийг үйл ажиллагаа тогтмолжоогүй, эхлэл төдий байна.

**Зөвлөмж:**

- Хичээлүүдийн стандартыг боловсронгуй болгох
- Сургалтын удирдлага мэдээллийн системийг үйл ажиллагаа тогтмолжуулах
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсронгуй болгох

**2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж ӨҮТ63-68
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал ӨҮТ63-69
- Идэвхитэй сургалтын аргуудыг ашиглаж буй байдал болон сургалтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээг тус тус сүүлийн 5 жилээр, мөн цахим хичээлийн хамрагдалт, хүлээн авч буй байдлыг тус тус судалсан байна. ӨҮТ70-73

**Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцахуйн болон багшлахуйн арга зүйг БСШУЯ-ны 2014 оны А/174, Дархан дээд сургуулийн багшийн журам зэрэг дээр тулгуурласан
- Багш нарын сургалтад хэрэглэж буй сургалтын идэвхтэй аргуудад анализ хийж давуу ба сул талыг тодорхойлсон

**Анхаарахасуудал:**

- Хүснэгт 25, график11,12 байгаа цахим хичээлийн чанар хүртээмжийн талаарх судалгаа нь оновчгүй болжээ.
- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцэлтэй, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй эсэх, мөн МХТ хэрхэн ашигладаг нь тодорхой бус байна.

**Зөвлөмж:**

- Хичээлүүд дээрээ суралцагч төвтэй, асуудал шийдвэрлэх болон төсөлд суурилсан сургалтын арга зүйг хэрэглэхэд анхаарах

**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/ ӨҮТ73-76
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам ӨҮТ77-78
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/ ӨҮТ79-80

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад оюутны мэдлэг, чадварын түвшинг явцын үнэлгээ, бие даалтын үнэлгээ, эцсийн үнэлгээ хэмээн үе шаттайгаараар үнэлдэг
- Оюутныг үнэлэх үнэлгээний системтэй. Үнэлгээндээ Блумын таксономи, рубрик, уламжлалт болон бусад аргуудыг ашигладаг
- Суралцагчдын үнэлгээ ил тод, шударга, тэгш зарчмыг хангахын төлөө ажилладаг

**Анхаарах асуудал:**

- Хичээл нэг бүрийн CLO-г хэрхэн үнэлдэг нь тодорхой бус.Үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/байсангүй
- Тухайн хичээлийн суралцахуйн үр дүн бүрийг оюутан хэрхэн эзэмшсэнийг үнэлж, хүрэх ёстой түвшинтэй харьцуулсан судалгаа дутмаг

- Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын сан зэрэг үнэлгээний даалгаврын санд анализ хийгдээгүй
- Суралцагчдын голч онооноос өөр судалгаа хийгдээгүй

**Зөвлөмж:**

- Хичээл тус бүрийн суралцахуйн үр дүнг CLO-г үнэлэх даалгавруудыг түвшин тус бүрээр боловсруулах

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Нэг оюутанд ногдох талбайн хэмжээ нь стандарт шаардлага хангасан байдал
- “Маш сайн”, “сайн” гэж нийт суралцагчдын 50-иас дээш хувь нь үнэлсэн сэтгэл ханамжийн судалгаа
- Мэдээллийн технологийн хувьд компьютерийн лаборатори, интернет төвтэй ба интернет хурдны үзүүлэлт жил бүр өссөн явц, цахим орчны хүртээмж нэмэгдсэн үзүүлэлт

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- ДаДС нь сургалт зохион байгуулах эрүүл аюулгүй, тохилог орчин бүрдүүлсэн
- Хичээлийн 3 байртай, 1200 оюутан суралцах боломжтой, байрнуудын нийт талбай 4934 м$^2$
- Нэг танхимд байх оюутны тоо стандарт хэмжээнээс бага буюу анги дүүргэлт хэтрээгүй. Нийт 65 өрөө тасалгаатай. Нэг суудалд ногдох талбай: лаборатори-2 м$^2$, кабинет 3.9 м$^2$ бол оюутны байрны нэг оюутанд ногдох ашигтай талбай 4.5 м$^2$
- Тус сургууль нь сургалтын 4 лаборатори, 3 кабинет, 2 төв, 8 дадлагын баазтай

- Нэг оюутанд ногдох талбайн хэмжээ, сандал ширээний хүрэлцээ зэрэг нь дээд боловсролын сургулатын байгууллагад тавигдах стандарт шаардлагыг бүрэн хангасан
- Оюутнууд “Төсөлт ажил 1-3”, “Судалгааны арга зүй” хичээл дээр багаар ажиллаж судалгаа, шинжилгээний ажил хийхээр хөтөлбөрт тусгагдсан нь оюутнуудын багаар ажиллах чадварыг хөгжүүлнэ. Оюутнуудын багаар ажиллах нөхцөлийг хангасан
- Хөтөлбөрийн багш нар ордог хичээлүүдийг цахим хэлбэрээр Google Drive, Facebook-т байршуулсан тул оюутан хичээлийн материалаа бие даан уншиж танилцах, өөрийн болгох боломжийг бүрдүүлж байна
- Номын санд “Чимээгүй танхим”-ыг байгуулсан. Уг танхимд оюутнууд бие даан ажиллах, ном сурах бичиг унших нөхцөлийг бүрдүүлсэн
- Лекцийн танхимд байвал зохих тоног, төхөөрөмжүүд бүрэн суурилагдсан.
- Сургуулийн байр, дотуур байр, анги танхим нь сургуулийн зориулалттай, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлсэн

**Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн кабинетуудад шаардлагатай техник хангамжийн хүрэлцээ, тоног төхөөрөмжийн өнөө үеийн шаардлага

**Зөвлөмж:**

- Сургалтын техник болон программ хангамжид түлхүү ач холбогдол өгч, хүрэлцээ, хүртээмжид анхаарах
- Оюутнуудын цахим орчны ашиглалт, чанарыг нэмэгдүүлэх

### 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын лаборитори, кабинет, төвүүд болон багш нар компьютер техник хэрэгсэлээр зохих түвшинд хангагдсан байдал.
- Сургалтын ажлыг зохион явуулах батглагдсан заавар, удирдамж, зөвлөмжөөр хангагдсан байдал.
- Багш нарыг сургалт явуулахад шаардлагатай хэвлэмэл үзүүлэн, тараах материал, аудио болон видео эх үүсвэр, программ хангамжуудаар зохих тевшинд хангагдсан байдал
- 2020-2021 оны хичээлийн жилд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж 20 гаруй судлагдахууныг Е-контент түвшинд боловсруулж цахим ангиар дамжуулан оюутан сурагчдад хүргэсэн

- Цахим сургалтын ULMS системийг хөгжүүлэн сургалтаа зохион байгуулж буй үйл ажиллагаа

**Шалгуурыг хангасан байдал:** Хэсэгчлэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын хөтөлбөрийн хүрээнд техник хэрэгсэл сайжруулахад чиглэсэн зардлыг жил бүр төсөвт нэмэгдүүлэн тусгаж, материаллаг баазаа нэмэгдүүлэхэд анхаарч байна.
- Сургалтын лабориториудад ашиглагдах нийт компьютерийн тоог нэмэгдүүлсэн
- Сургалтад ашиглаж буй программуудын ашиглалт, хэрэглээ зохих түвшинд

**Анхаарах асуудал:**

- Судалгааны программ хангамжийг нэмэгдүүлэх, судалгааны боловсруулалтын программуудаас суралцах
- Сургалтад хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн багцийг шинэчлэх, нэмэгдүүлэх
- Оюутны гүйцэтгэх бие даалт нь зарим хөтөлбөрүүдэд ижил, үнэлгээний рубрик хийсэн боловч оновчгүй.

**Зөвлөмж:**

- Цахим хэрэглэгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх
- Оюутнуудын эргэх холбоо, бие даалтын ажлыг цахимжуулах

### 3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилтыг тухайн сургуулийн санхүүгийн байдал, оюутны тоотой уялдуулан авч үзвэл боломжийн (7,6 сая)
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаагаар номын сангийн үйлчилгээний үзүүлэлт бусад үзүүлэлтээс өндөр байгаа байдал
- "Оюутан-номын санч" клубыг байгуулан оюутнуудыг идэвхжүүлэх, манлайлагчдыг сурталчлан таниулж үлгэрлүүлэх, үйлчилгээгээ өнгөржүүлэхэд чиглэсэн ажлууд
- Lib4U программд 17,0 мянга гаруй ном сурах бичгийг оруулж, электрон катологи болсон

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилтыг тухайн сургуулийн санхүүгийн байдал, оюутны тоотой уялдуулан авч үзвэл боломжийн хийгдсэн
- 2019-2021 онуудад Е-контент түвшинд 700 гаруй ээлжит хичээлийн сан үүсгэсэн үзүүлэлт
- Оюутны дотуур байранд номын сангийн үйлчилгээг хүргэж үйлчилдэг
- Номын сан нь бусад номын сангуудтай хамтран ажиллаж, электрон катологитой болж, утасгүй интернетийн орчинг бүрдүүлсэн

**Анхаарах асуудал:**

- Номын сангийн утасгүй интернетийн орчинг улам сайжруулж, оюутнуудын хамрагдах хүртээмж, чанарт анхаарах.
- Ном, сурах бичиг худалдан авахад зарцуулсан зардлын хэмжээг бууруулахгүй харин ч нэмэгдүүлэхэд анхаарах
- Өнөө үеийн шаадлагад нийцэхүйц цахим номын санг бий болгох, хөгжүүлэхэд анхаарах

**Зөвлөмж:**

- Номын сангийн үйлчилгээгээ цахимжуулахад түлхүү анхаарч, шат дараатай төлөвлөн гүйцэтгэх
- Номын сангийн үйлчилгээнд хамрагдах хүртээмж, чанарт чиглэсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичиг, түүний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал, гомдол, шийдвэрлэлтийн тайлан

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө
- Сургалтын удирдлага мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Тухайн хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ,санхүүжилт, хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт, хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдлыг тодорхойлсон.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ БСШУ-ны боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Дархан дээд сургуулийн баталсан дүрэм журмыг баримталдаг.
- Хөтөлбөрийг тэнхим санаачилж, саналаа хөтөлбөрийн хороонд бичгээр өгдөг. Хөтөлбөрийн хороо хэлэлцээд Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, захирлын тушаалаар батламжилдаг.
- Хичээлийн жилийн эхэнд улирал жилээр төлөвлөгөө гарган, тайлангаа хэлэлцүүлдэг механизм бүрдсэн.
- Оюутны санал, гомдлыг журмын дагуу шийдвэрлэдэг.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийг хөтөлбөрийн удирдлага, багш, суралцагчид ашиглаж байсан.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хороогоор хэдэн удаагийн давтамжтай хэдэн хөтөлбөр баталсан, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлдэг эсэх талаар тусгаагүй.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ тусгагдаагүй.
- Урт, богино хугацааны төлөвлөгөө, тайланд тусгагдсан ахиц дэвшлийг дурьдаагүй.
- Жил бүр хэдэн оюутны ямар санал гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл тодорхойгүй.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийг ямар хэлбэрээр ашиглаж байгаа, түүнийг ашигласнаар гарсан өөрчлөлтийг дурьдаагүй.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийж, тайлан тусгах
- Урт, богино хугацааны төлөвлөгөө, тайланд ахиц дэвшлээ бичих
- Жил бүр хэдэн оюутны санал гомдлыг хэрхэн шийдсэнээ тайланд нэгтгэж бичих
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн үйл ажиллагааг тогтмолжуулах

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэг хөтөлбөри хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- БНХАУ-ын Өвөр Монгол, ОХУ-ын Новосибирск Улан-Удэ,БНСУ-ын Ивонг их сургуулиудтай хамтын ажиллагаатай.
- Багш, суралцагч солилцох талаар төлөвлөгөөндөө тусгасан.
- Бусад байгууллагуудтай хамтран 11 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж , тогтмолжсон.
- Төгсөгчдийн холбоо нь сургалт, хэлэлцүүлэг, уулзалт,спортын тэмцээн,уралдаан,үзэсгэлэн, хурал зохион байгуулсан ба цаашид хийх ажлаа төлөвлөсөн.
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах, бодлого төлөвлөгөөтэй.

**Анхаарах асуудал:**

- СХУ-ны тэнхим нь сургалт, судалгаа, багш, оюутан солилцооны чиглэлээр хамтарч ажилладаг гэсэн боловч хамтарсан төсөл, хөтөлбөр цөөхөн учраас эдгээр ажлын үр дүн хөтөлбөрийн хөгжил шинэчлэлтэд хэрхэн нөлөөлдөг нь тодорхойгүй.
- Багш, суралцагч солилцдог гэсэн атлаа хаана хэдэн багш, оюутан солилцсон тоон судалгаа тусгагдаагүй.

**Зөвлөмж:**

- Багш нар хамрагдсан төсөл хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн хөгжилд хэрхэн нөлөөлж буйг тайландаа тусгах
- Багш, суралцагч солилцооны тоон судалгаа хийж, тайланд оруулах

### 4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчтэнхимийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг 5 жилээр гаргасан.
- Орлогын 51,1- 60,8 % нь хөтөлбөрт зарцуулагддаг.
- Нэг оюутанд ноогдох өртөг зардлын тооцоо хийсэн.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжид санхүүгийн болон бусад дэмжлэгийг авч ажилладаг.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн хувьд бие даасан байдалтай, тодорхой хэмжээний эрх зүйн зохицуулалт хийгдсэн эсэх нь тодорхойгүй.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсвийг тайланд оруулаагүй.

**Зөвлөмж:**

- Тухайн хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт өөрчлөлтөд зориулсан төсвийг нийт төсвөөс ялгаж оруулах

### 4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ,тайлан,баримт

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 2019-2021 онуудад хийсэн.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол хийдэг бөгөөд 72-85 хувь нь мэргэжлээрээ ажилладаг.
- Хөтөлбөрийг төгсөгчдийн уулзалт, сонин сэтгүүл, цахим хуудсаар сурталчилдаг.

**Анхаарах асуудал:**

•Хөтөлбөрийг сурталчилдаг гэснээс үр ашиг, хамрах хүрээ нь тодорхойгүй.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг сурталчлахаас гадна үр ашиг, хамрах хүрээг тодорхойлж тайланд тусгах

### 4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл,ном, товхимол, гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вэб сайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

